

## ӨМГӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

(Дэлгэрэнгүй танилцуулга)

Нэг. Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6-д хуульчийг өмгөөлөгчийн шалгалтад оруулахаас татгалзах тохиолдолдлыг тусгасан ба 8.6.3-т “энэ хуулийн 15.1.12, 15.1.13-т заасан өмгөөллийн үйл ажиллагаатай хавсран эрхэлж болохгүй ажил албан, тушаал эрхэлж байгаа” гэж заасан нь шалгалтад орох хуульчийн эрхийг дор тайлбарласан үндэслэлээр зөрчиж байна.

Өмгөөллийн тухай хуулийн 15.1.12, 15.1.13-т өмгөөллийн үйл ажиллагаанд хавсран эрхэлж болохгүй албан тушаалыг тусгайлан заасан нь өмгөөллийн үйл ажиллагааг хараат бусаар эрхлэх боломжийг бий болгох зорилготой юм. Тухайлбал, өмгөөлөгч нь төрийн албан тушаалыг хавсран эрхэлсэн тохиолдолд шүүн таслах үйл ажиллагаанд нийгмийн бүхий л салбарт ажиллаж, амьдарч байгаа этгээдийн хууль ёсны төлөөлөгч болохын хувьд албан тушаалтны нөлөөнд автах эсхүл ажил, албан тушаалаар дамжуулан нөлөөлөх, давуу байдал үүсгэх зэрэг эрсдэлийг үүсгэнэ гэж үздэг.

Гэтэл хуульчийг өмгөөллийн үйл ажиллагаа явуулах эрх авах эсэх нь тодорхойгүй үе шат буюу өмгөөллийн шалгалтад бүртгүүлэхэд тус хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12, 15.1.13-т заасан ажил, албан тушаалаас чөлөөлөгдөхийг шаардах нь хуульчийн эрх зүйн байдалд сөрөг үр дагавар бий болгож байна. Хуульч өмгөөллийн эрх авах шалгалтад оролцоод тэнцэхгүй байх, эсхүл тэнцсэн ч хүсэлт гаргаж өмгөөлөгчдийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлж эрхээ авахгүй байх эрх нь нээлттэй байдаг тул хуульч шалгалтад бүртгүүлэхэд энэ хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12, 15.1.13-т заасан ажил, албан тушаалаас чөлөөлөгдөхийг шаардахгүй байх нь зүйтэй.

Хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд Монголын Өмгөөлөгчдийн Холбооноос холбогдох санал, судалгааг хүлээн авч, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх шалгалтад бүртгүүлэх хүсэлт гаргасан иргэдээс Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3-т заасан зохицуулалттай холбогдуулан гомдол, хүсэлт ирсээр байгааг илэрхийлсэн. Тухайлбал, 2023 онд Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох шалгалтад нийт 283 хуульч бүртгүүлэх хүсэлт гаргасны 238 хуульчид шалгалтад орох эрх олгож, харин 45 хуульчийг Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3-т заасан “энэ хуулийн 15.1.12, 15.1.13-т заасан өмгөөллийн үйл ажиллагаатай хавсран эрхэлж болохгүй ажил албан, тушаал эрхэлж байгаа” гэх үнлэслэлээр бүртгэхээс татгалзсан байна.

Дээрх 45 хуульчийн 14 хуульч нь Монголын Өмгөөлөгчдийн Холбооны Ерөнхийлөгчид хандан шалгалтад бүртгэхээс татгалзсан шийдвэр нь тэдгээрийн эрх ашгийг хөндөж байгаа тухай гомдол гаргасан байна.

Түүнчлэн, Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалт нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг болон Арван зургаадугаар зүйлийн 4 дэх заалтыг зөрчсөн асуудлаар Монгол Улсын иргэн Э.Түмэнбаяр 2022 онд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандан мэдээлэл ирүүлсний дагуу маргаан

хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэж үүний дагуу Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2022 оны 02 дугаар дүгнэлтийг гаргасан байна. Уг дүгнэлтээр тухайн заалт нь Үндсэн хууль зөрчөөгүй гэж дүгнэсэн боловч үндэслэх хэсэгт Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалт Үндсэн хуульд заасан ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийг хязгаарласан байх магадлалтай гэж хүлээн зөвшөөрсөн байна.

Түүнчлэн энэхүү маргаантай ижил асуудлаар иргэн Б.Гантөмөрөөс гаргасан мэдээллийн дагуу Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэсэн байх ба Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад зааснаар урьд шийдвэрлэсэн маргааныг дахин хянан шийдвэрлэх талаар Цэцийн гишүүдийн олонхи санал гаргасныг үндэслэн уг маргааныг Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар хэлэлцүүлэх болсон тухайг Үндсэн хуулийн цэцийн даргын 2024 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 21 дүгээр тогтоолд дурдсан байна.

Хоёр. Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн зорилго нь аливаа хуульч нь өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх шалгалтад хууль бус хязгаарлалтаас ангид байж, тухайн шалгалтад бүртгүүлэх, оролцох боломжоор хангагдах, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийг эдлэхэд оршино.

Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар томъёолж тусгав:

- Хуулийн төслийн нэгдүгээр зүйлд “Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай” гэж;
- Хуулийн төслийн хоёрдугаар зүйлд “Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө” гэж.

Гурав. Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, эрх зүйн хөгжилд чухал ач холбогдол бүхий бодлогын чанартай дараах үр дагавар бий болно гэж үзэж байна:

Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл батлагдсанаар тус хуулийн бусад зохицуулалт хөндөгдөхгүй бөгөөд хуульч нь өмгөөлөгчийн шалгалтанд тэнцэж, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг авахдаа Өмгөөллийн тухай хуулийн 15.1.12, 15.1.13-т заасан өмгөөллийн үйл ажиллагаатай хавсран эрхэлж болохгүй ажил албан, тушаалаас чөлөөлөгдөх хуулийн шаардлагыг хэрэгжүүлэх боломж бүрдэх юм. Ингэснээр нэг талаас, иргэн ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрх хангагдах ба нөгөө талаас өмгөөллийн үйл ажиллагааг хараат бусаар эрхлэх боломжийг бий болгох хуулийн зорилго хөндөгдөхгүй, зөв хэрэгжих нөхцөл хангагдана.

Энэхүү хуулийн төслийг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр <https://d.parliament.mn/tusul/ab1c1ae7-d0dd-4f12-8b47-c5b85fdc5d18> цахим хуудаст олон нийтээс санал авахаар байршуулсан бөгөөд 2025 оны 3 дугаар сарын 06-ны өдрийг хүртэл олон нийтээс санал ирүүлээгүй болно.

**ХУУЛЬ САНААЧЛАГЧ**

## ӨМГӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

(Товч танилцуулга)

Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хууль болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан журмын хүрээнд боловсрууллаа.

Хууль санаачлагчийн зүгээс тус хуулийн төслийн хэрэгцээ шаардлага, үндэслэлийг судлах зорилгоор холбогдох мэргэжлийн байгууллагын байр суурь, саналыг сонсох, хуульчдаас ирүүлсэн гомдол, хүсэлтийн судалгааг авах мөн Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалттай холбогдуулан Үндсэн хуулийн цэцээс явуулсан маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүн, шийдвэр дүгнэлттэй танилцах зэрэг холбогдох судалгааг хийж, дүгнэлт гаргасан болно.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3-т хуульчийг өмгөөлөгчийн шалгалтад оруулахаас татгалзах тохиолдлын нэг нь “энэ хуулийн 15.1.12, 15.1.13-т заасан өмгөөллийн үйл ажиллагаатай хавсран эрхэлж болохгүй ажил албан, тушаал эрхэлж байгаа” гэж заасан нь шалгалтад орох хуульчийн эрхийг зөрчиж, Монгол Улсын Үндсэн хуульд заасан ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийг хязгаарласан бодит нөхцөл байдал үүсгэж байгаа бөгөөд иргэний Үндсэн хуулиар олгогдсон эрхийг хангах зорилгоор энэхүү төслийг боловсрууллаа.

Энэхүү хуулийн төсөл нь хоёр зүйлээс бүрдэх ба Нэгдүгээр зүйлд, Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцох тухайг тусгалаа. Хоёрдугаар зүйлд, хуулийн хүчин төгөлдөр мөрдөж эхлэх хугацааг заасан болно.

Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл батлагдсанаар аливаа хуульч нь өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийн шалгалтад хууль бус хязгаарлалтаас ангид хамрагдах боломж бүрдэж, хуулийн зорилгыг гажуудуулсан, хуулийн бусад зүйл заалттай зөрчилдсөн зохицуулалт засварлагдана гэж харж байна.

**ХУУЛЬ САНААЧЛАГЧ**